



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 1/03

Шивээговь сум

Арга хэмжээ зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Монгол Улсын ерөнхийлөгчийн 2022 оны 07 дугаар сарын 11-ний өдрийн “Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай” 159 дүгээр зарлиг дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Монгол Улсын ерөнхийлөгчийн 2022 оны 07 дугаар сарын 11-ний өдрийн “Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай” 159 дугаар зарлигийн хэрэгжилтийг хангаж, албан байгууллага, айл өрх бүр, Эзэн Богд Чингис хааны эш хөргийг дээдлэн залж, суу алдар билиг сургаалыг ажилтан албан хаагч, иргэд айл өрх бүрт сурталчлан таниулж эрчимжүүлэх ажлын хүрээнд төрийн байгууллагуудын дунд “ЧИНГИС ХААНЫ ЭШ ХӨРГИЙГ ХОЙМОРТОО ЗАЛЪЯ” фото зургийн уралдааныг 2023 оны 04 сарын 10-ны өдрөөс 05 дугаар сарын 17-ны өдрийг хүртэл зохион байгуулсугай.

2. Арга хэмжээний удирдамжийг 1 дүгээр хавсралтаар, арга хэмжээний зардалд зарцуулагдах төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.


3. Арга хэмжээний төсвийн дагуу 600,000 (зургаан зуун мянга) төгрөгийг “Хөтөлбөрт суурилсан төсвийн төлөвлөлт”-ийн зардлаас зохих журмын дагуу анхан шатны баримт бичгийн бүрдлийг ханган зарцуулахыг нягтлан бодогч (Д.Сэлэнгээ)-д даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Сугармаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П. ГАНЧИМЭГ



Сумын Засаг даргын  
2023 оны 05-р сарын 16-ны өдрийн  
А/63 Захирамжийн хавсралт 1

**ЧИНГИС ХААНЫ ИШ ХӨРГИЙГ ХОЙМОРТОО ЗАЛЪЯ**

**2023.05.15**

Шивээговь сумын төрийн байгууллага болон ААН-ийн дунд зохион байгуулж буй “Чингис хааны иш хөргийг хоймортоо залъя” сэдэвт фото зургийн уралдаан зарлаж байна.

**Зохион байгуулагч:**

Шивээговь сумын ЗДТГ

**Зорилго:**

Албан байгууллага, ААН, Эзэн Чингис хааны иш хөргийг дээдлэн залж, суу алдар билиг сургаалыг ажилтан албан хаагч, иргэд айл өрх бүрд сурталчлан таниулж эрчимжүүлэн ажиллах зорилготой.

**Хамрах хүрээ:**

Шивээговь сумын албан байгууллага болон аж ахуйн нэгж

**Тавигдах шаардлага:**

- Хамрагдсан ажилчдын тоог нотлох баримттай тайлан мэдээг ирүүлэх
- 1278 онд монгол зураач Хорихосон уралсан эш хөрөг байх. Энэхүү иш хөргийг доорх холбоосоор татаж авч болно.

[/https5//e-mongolia.mn/chingis-khaanii-esh-khurug](https://e-mongolia.mn/chingis-khaanii-esh-khurug)

- Албан байгууллагын нийт ажилчид 100% хамрагдсан байх

**Хугацаа:**

2023 оны 04 сарын 15-аас 05 сарын 01-ний өдөр хүртэл

**Шагнал урамшуулал:**


- 1-р байр-250,000 төгрөг
- 2-р байр- 200,000 төгрөг
- 3-байр- 150,000 төгрөг

**Материалыг хүлээн авах газар:**

Шивээговь сумын ЗДТГ-т

Уралдааны талаар мэдээлэл авах утас: 94188828

Сумын Засаг даргын  
2023 оны 05 -р сарын 16 -ны өдрийн  
А/63 Захирамжийн хавсралт 2



**ЧИНГИС ХААНЫ ИШ ХӨРГИЙГ ХОЙМОРТОО ЗАЛЪЯ ФОТО ЗУРГИЙН  
УРАЛДААНЫ ТӨСӨВ**

2023.05.15

	Нэр	Зориулалт	Тоо (ширхэг)	Ширхэгийн мөнгөн дүн	Нийт
1	I байр мөнгөн шагнал	Байгууллага	1	250.000	250.000
2	II байр мөнгөн шагнал	Байгууллага	1	200.000	200.000
3	III байр мөнгөн шагнал	Байгууллага	1	150.000	150.000
<b>Нийт</b>					<b>600.000</b>

**Төсөв гаргасан:**

Нийгмийн бодлогын мэргэжилтэн:

Б.Алтансүх